

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ



ЖИЛИЙН ТАЙЛАН 2025

УЛААНБААТАР ХОТ



Мөндчилгээ



Сайн байцгаана уу?

“Үндэсний давхар даатгал” ХК нь өнгөрсөн хугацаанд Монгол улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт хөгжилд бодит хувь нэмрээ оруулж, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг амжилттай үзүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд компанийн нийт хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд тогтвортой өссөн амжилттай жил болж өнгөрөв.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлаг 2025 оны 12 дугаар

сарын 04-ний өдөр манай компанийн санхүүгийн чадавхыг В, урт хугацааны зээлжих зэрэглэлийг BB+, цаашдын төлөвийг “Тогтвортой” хэмээн дахин үнэлсэн нь бидний олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа, оновчтой эрсдэлийн удирдлага, тогтвортой бизнесийн загварыг баталгаажуулсан чухал үнэлгээ боллоо.


Өнөөдөр уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн тодорхой бус байдал, ээдрээтэй, эрсдэл өндөртэй геополитикийн нөхцөл байдлын нөлөөгөөр нийгэм, эдийн засгийн орчин улам бүр сорилттой болж байна. Ийм нөхцөлд давхар даатгал нь эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах гол хамгаалалтын механизм болж байгаа билээ. Байгууллагын мэргэшсэн баг хамт олны ур чадвар, санхүүгийн чадавхаа тасралтгүй бэхжүүлэн, эрсдэлийг хуваалцах, шилжүүлэх үйлсэд хариуцлагатайгаар оролцож байна.

Цаашид бид харилцагч, түнш байгууллагуудтайгаа хамтран зах зээлийн хэрэгцээнд нийцсэн стратегийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхаа нэмэгдүүлэх замаар бизнесийн байгууллагууд болон иргэдийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад бодит хувь нэмрээ оруулсаар байх болно.

Бидэнтэй хамтран ажилладаг эрхэм түнш, харилцагчид та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
БАТМӨНХИЙН ЖАВХЛАНТ



➤ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



АЛСЫН ХАРАА:

Бид

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг дээдлэгч, Төв Азийн тэргүүлэх давхар даатгагчдын нэг, Мэргэшлийн дээд түвшний стандартыг тогтоогч, Монгол Улсын давхар даатгалын жишиг компани, Мэргэжлийн хөрөнгө оруулагч болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС:

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн алсын хараа, эрхэм зорилгод тусгасан зорилго, чиглэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах үнэт зүйлсийг мөрдлөг болгон ажиллана.

МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ: Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин

МАНЛАЙЛАЛ: Цаашдын зорилго, зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

ХАМТЫН ЗҮТГЭЛ: Бусадтай хүндлэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ: Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөж, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ИЛ ТОД ХАРИЛЦАА ХОЛБОО: Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

“Үндэсний давхар даатгал” ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм.

Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас гурав дахь жилдээ ерөнхий санхүүгийн чадавхын хувьд В, урт хугацааны зээлжих зэрэглэлийн хувьд ВВ+, цаашдын төлөвтөө “Тогтвортой” үнэлгээ аван баталгаажуулж, компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, компанийн хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн болон чанарын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ISO стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Бид олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллахдаа олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудын хамгийн өндөр үнэлгээ бүхий дэлхийн шилдэг давхар даатгалын компаниудтай хамтран ажиллаж харилцагчдынхаа эрсдэлгүй байдлыг ханган ажиллаж, давхар даатгалын үйлчилгээг экспортолж эхлээд байна.

КОМПАНИЙН БҮТЭЦ



➤ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУДЫН ХЭРЭГЖИЛТ

➤ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуульд заасны дагуу “Үндэсний давхар даатгал” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид (ХЭ)-ийн хурал байна. ХЭ-ийн хурлын бүрэн эрхийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн сайд хэрэгжүүлдэг.

➤ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2-т заасны дагуу ХЭ-ийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) юм. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд зааснаар ТУЗ 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2 болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

ТУЗ нь үйл ажиллагаагаа байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дэргэдээ “Аудитын”, “Цалин, урамшууллын”, “Нэр дэвшүүлэх”, “Эрсдэлийн” гэсэн хороодыг байгуулан ажиллаж байна.

➤ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

➤ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардлагатай дүрэм, журам, бодлогын баримт бичгийг өөрийн компанийн онцлогт нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар батлуулсан. Үүнд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам
3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журам
5. Дотоод аудитын журам
6. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам
7. Комплаенсын хяналтын журам
8. Мэдээллийн ил тод байдлын журам
9. Ажилтны ёс зүйн дүрэм
10. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
11. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг
12. Эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал
13. Залгамж халааны бодлогын баримт бичиг
14. Ногдол ашигтай холбогдох үйл ажиллагааг зохицуулах журам
15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах журам
16. Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг
17. Ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам
18. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг
19. Хөрөнгө орулагчидтай харилцах хөтөлбөр

Эдгээр дүрэм, журам, бодлогын баримт бичиг болон “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

"ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ (2025 оны 4 дүгээр улирлын байдлаар)					
	Компанийн засаглалын кодексын зарчмууд	Хэрэгжилт	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6
1	НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.	Хэрэгжүүлж ажилласан	12	12	100%
2	ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.	Хэрэгжүүлж ажилласан	10	10	100%
3	ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
4	ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
5	ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.	Хэрэгжүүлж ажилласан	8	7	87.5%
6	ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
7	ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.	Хэрэгжүүлж ажилласан	8	8	100%
8	НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
9	ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.	Хэрэгжүүлж ажилласан	10	10	100%
Нэгдсэн дүн			72	71	98.6%



▶ САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ

ӨРСӨЛДӨХ ДАВУУ ТАЛУУД БОЛОН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ТУСГАСАН.

Санхүүгийн чадавхийн
үнэлгээ (FSR)

B Fair
Төлөв: Тогтвортой Үйлдэл: Баталгаажсан

Зээлжих зэрэглэлийн
үнэлгээ (ICR)

BB+ Fair
Төлөв: Тогтвортой Үйлдэл: Баталгаажсан

Үнэлгээ
www.ambest.com

Санхүүгийн чадавх	Маш өндөр
Үйл ажиллагааны гүйцэтгэл	Хангалттай
Бизнесийн үндсэн чиглэл	Хязгаарлагдмал
Байгууллагын эрсдэлийн удирдлага	Зохистой

Монгол Улс дахь хүчирхэг брэнд болон зах зээлийн байр суурь

Үндэсний цорын ганц давхар даатгагчийн хувьд дотоодын зах зээлд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ Ази болон бусад зорилтот зах зээлүүдэд оролцоогоо тэлж байна.

Дотоодын зах зээл дэх давуу байр суурь

Дотоодын ердийн даатгагчидтай тогтвортой хамтын ажиллагаа, бодлогын дэмжлэг болон давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх төрийн дэмжлэгтэй компани.

Оновчтой хөрөнгө оруулалтын стратеги

Системийн ач холбогдол бүхий банкуудад хадгаламжаа байршуулдаг.


Хөрөнгийн хүрэлцээт байдал

Хөрөнгийн түвшин хангалттай, андеррайтингийн хөшүүрэг зохистой түвшинд хадгалагдаж, байгалийн гамшгийн эрсдэлд өртөх байдал хязгаарлагдмал байна.

Санхүүгийн уян хатан байдал

Өрийн дарамт багатай, хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн эх үүсвэрүүдэд нэвтрэх боломжтой, тогтвортой хөрөнгө оруулагчийн суурьтай.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС




САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант онд компанийн хөрөнгө 67 тэрбум 808 сая төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын нийт хөрөнгийн 8.8 хувийг эзэлж байна. Даатгалын хураамж өнгөрсөн жилээс 48 хувь буюу 3.7 тэрбум төгрөгөөр өсч, 11 тэрбум 413 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлснээр даатгалын зах зээл дэх нийт давхар даатгалын хураамжийн 5.8 хувийг бүрдүүллээ.


НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/




НИЙТ ОРЛОГО БА ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



ДААТГАЛЫН ХУРААМЖ /тэрбум төгрөг/



НӨӨЦ САН /тэрбум төгрөг/




➤ ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай давхар даатгалын үйлчилгээ нь эрсдэлийн удирдлага, олон улсын хамтын ажиллагаанд суурилж, найдвартай, тогтвортой, мэргэжлийн үйл ажиллагааг харилцагчиддаа санал болгодог. Бид зах зээлийн шаардлагад нийцсэн, үр ашигтай, урт хугацааны хамтын ажиллагааг эрхэмлэдэг.

Бид даатгагчдын хэрэгцээ, эрсдэлийн онцлогт нийцсэн дараах даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээнд факультатив болон трити давхар даатгалын шийдлүүдийг санал болгож байна.

Давхар даатгалын хамгаалалт үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ

- Хөрөнгийн даатгал
- Хариуцлагын даатгал
- Малын индексжүүлсэн даатгал
- Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал
- Барилга угсралтын даатгал (CAR/EAR)
- Баталгааны даатгал
- Санхүүгийн даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Тусгай зориулалтын болон хүнд машин механизмын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Агаарын хөлгийн даатгал
- Агаарын хөлгийн хариуцлагын даатгал



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу “Үндэсний давхар даатгал” ХК нь Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй.

МИД-ын борлуулалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл оролцогч “Ард” даатгал ХК, “Бодь даатгал” ХК, “Миг даатгал” ХХК, “Монгол

даатгал” ХК, “Мөнх даатгал” ХХК, “Практикал” даатгал ХХК, “Хаан даатгал” ХХК болон зуучлагч ХААН банк, Төрийн банктай хамтран зохион байгуулж нийт 23,109 малчин өрхийн, 122 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 3,48 сая толгой малыг даатгалд хамруулж, малчин өрхийн 11.8%, малын 6.0% нь МИД-д хамрагдсан байна.

/сая төгрөг/

Тайлант он	2022	2023	2024	2025
Даатгалын нийт хураамж	3,912	4,965	3,728	4,163
Даатгуулсан малчин өрх	27,456	35,703	21,425	23,109
Давхар даатгалын хураамж	1,296	1,688	1,404	1,740

МИД хэрэгжсэн 20 жилийн хугацаанд давхардсан тоогоор 373,6 мянган малчин өрхийн 76.7 сая толгой малыг даатгалд хамруулж, 43 тэрбум 800 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 81.9 мянган малчин өрх нийт 29.3

тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид амьдрал дээр бодитойгоор хүртээд байна.



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

УИХ-ын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг баталж, 2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр боллоо. Хуульд дараах 2 гол өөрчлөлтийг тусгалаа.

1. Босго үзүүлэлтийг 6 хувь байсныг 5 хувь болгон буурууллаа.

МИД-ын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалтын үр дүн, МИД-д оролцогч талуудаас авсан судалгаа, малын хорогдлын түүхэн мэдээлэл, МИД-ын үр дүнгийн мэдээлэлд үндэслэн босго үзүүлэлт 6 хувь байсныг 5 хувь болгон буурууллаа. Босго үзүүлэлтийг сум тус бүрээр эрсдэлийн түвшнийг харгалзан ялгаатай тооцоолж, Засгийн газрын 2026 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор шинэчлэн баталлаа. Шинэчлэсэн босго үзүүлэлтээр 4 хувьтай 145 сум, 5 хувьтай 165 сум, 6 хувьтай 25 сум байна. Үүнд Монгол Улсын 330 сум, 5 дүүрэг багтсан болно.

Босго үзүүлэлтийг бууруулснаар малчдын Малын индексжүүлсэн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, даатгалын үр шимийг хүртэх, МИД-ын тухай хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх чухал ач холбогдолтой.


2. Зудын эрсдэлийн эрт санхүүжилтын эрх зүйн орчин бүрдлээ.

Гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, малчид даатгалын үр шимийг хурдан хүртэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор МИД-ын нөхөн төлбөрийн тодорхой хувийг малчдад урьдчилж олгохоор болсон. Ингэхдээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны мэдээнд үндэслэн урьдчилан олгож, хагас жилийн түүвэр судалгааны дүн мэдээ эцэслэн гарсны дараа нөхөн төлбөрийг эцэслэх юм.

Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр

Үндэсний статистикийн хорооны хагас жилийн мал тооллогын үр дүнд үндэслэн тооцоолж МИД-д 2024 онд даатгуулсан Архангай, Төв, Ховд зэрэг аймгийн 4 сумын 52 малчин өрхөд нийт 1,601,547 төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо. Нөхөн төлбөр авсан малчин өрх даатгалд хамрагдсан малчин өрхийн 0.24 хувийг эзэлж байна.


ДААТГАЛД ХАМРАГДСАН СҮРГИЙН БҮТЭЦ



➤ ГАДААД, ДОТООД ТҮНШЛЭЛ

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, борлуулалтын сувгийг тэлж сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэлийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж, холбогдох ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

Олон улсын хамтын ажиллагаа:





Дотоодын хамтын ажиллагаа:



САНГИЙН ЯАМ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР



Ard Даатгал
ХК



МАНДАЛ
ДААТГАЛ



BODI INSURANCE
INSPIRING ASSURANCE



ИНШҮРКО
ДААТГАЛ



ТӨРИЙН БАНК



ХААН БАНК



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн эрсдэлийн засаглал дараах зүйлсээс бүрддэг. Үүнд:

- Хамгаалалтын гурван шугам
- Засаглалын баримт бичгүүд
- Засаглалын хороод

Хамгаалалтын гурван шугам

Нэгдүгээр шугам: Компанийн газар нэгжийн бүх ажилтан
Хоёрдугаар шугам: Компанийн Эрсдэлийн хороо болон Эрсдэл хариуцсан газар нэгж
Гуравдугаар шугам: Дотоод аудитын алба

Засаглалын баримт бичгүүд

Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, аргачлал хамгаалалтын гурван шугамыг хэрэгжүүлэх баримт бичгүүд ордог.

Засаглалын Хороод

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Компанийн Эрсдэлийн хороо

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Компани нь “Хамгаалалтын гурван шугам”-ын зарчим бүхий эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлдэг. Энэ нь Компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулдаг.



➤

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагад тулгарч болзошгүй төрөл бүрийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах зэрэг үйл ажиллагааны шат дарааллаас бүрддэг бөгөөд уг тогтолцоог хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бодлого, журам, арга аргачлалуудыг боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Даатгалын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний голлох үзүүлэлт болох даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцааг тооцох замаар тодорхойлдог. Компанийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцааг зохистой доод түвшин болох 100 хувиас 3 дахин өндөр түвшинд хангаснаар, эрсдэл даах чадвар өндөр буюу нэгдүгээр түвшинд, түүнчлэн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа хүлээн зөвшөөрөх дээд түвшин болох 10 хувиас 10 дахин бага түвшинд байна. Улмаар компанийн төлбөрийн чадвар сайн ба нэгдүгээр түвшний эрсдэлийн үнэлгээтэй байна.

Харьцаа үзүүлэлтүүд	2023 он	2024 он	2025 он
Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа (Шалгуур $\geq 100\%$)	332%	326%	344%
Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа	1%	1%	1%
Төлбөрийн чадварын зохистой харьцаа	I түвшин	I түвшин	I түвшин
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (Шалгуур $\geq 110\%$)	130%	134%	137%



➤ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



- Үндэсний мод тарих өдөр буюу 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хамт олноороо 30 бут, буйлс мод тарьсан.
- Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд цусаа хандивлах аяныг зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хамт олноороо цусаа хандивлав.
- Хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилтнуудын хүүхдүүд, эцэг эхчүүдийг хамруулсан замын хөдөлгөөнд хэрхэн зөв оролцох дадал олгох болон гамшиг ослын үед авах арга хэмжээний талаар сургалт, нөлөөлөл (уулзалт, ярилцлага хийх)-ийн ажлыг зохион байгуулав.



➤ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)

“Үндэсний Давхар Даатгал” ХК нь Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) зарчмыг компанийн стратеги, эрсдэлийн удирдлагад уялдуулж, GRI (2021), SASB стандарт болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн БОНЗ-ын тайлангаа боловсруулав. Компанийн Байгаль орчин, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогоор үйл ажиллагааны тогтвортой байдал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлсэн. Засаглалын хүрээнд Компанийн засаглалын кодексын хэрэгжилт өндөр түвшинд үнэлэгдэж, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэн ажиллалаа. Цаашид “Үндэсний Давхар Даатгал” ХК нь БОНЗ-ын тайлагналыг тогтмол сайжруулж, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн эрсдэлд чиглэсэн даатгалын хамгаалалтыг өргөжүүлэх, ногоон санхүүжилт, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих замаар урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллана.



2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2025 он (мян.төг)	2024 он (мян.төг)
Даатгалын орлого	9,991,705*	7,386,567
Даатгалын үйлчилгээний зардал	(5,031,547)	(14,423,528)
Давхар даатгалын хураамжийн зардал	(3,801,287)	(3,102,413)
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	-	8,646,645
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн	1,158,871	(1,492,729)
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	8,628,675	8,530,702
Хөрөнгө оруулалтын орлого	8,628,675	8,530,702
Бусад орлого	113,491	202,044
Ерөнхий ба удирдлагын зардал	(5,276,829)	(4,556,665)
Бусад үйл ажиллагааны зардал	(327,885)	(705,969)
Бусад санхүүгийн зардал	(65,148)	(587)
Татварын өмнөх ашиг	4,231,175	1,976,796
Орлогын албан татварын зардал	(867,496)	(845,071)
Тайлант жилийн цэвэр ашиг	3,363,679	1,131,725

* Даатгалын орлого нийт дүнгээр 11,413,707 мянган төгрөгөөс даатгалын хураамжийн буцаалт болон орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өөрчлөлтийг нийт 1,422,002 мянган төгрөгөөр цэвэрлэж толилуулсан.

2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

	2025 оны 12-р сарын 31 (мян.төг)	2024 оны 12-р сарын 31 (мян.төг)
Хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,332,398	1,630,703
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө	62,618,443	57,967,999
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	1,456,483*	1,223,208
Бусад санхүүгийн хөрөнгө	2,165	388
Бусад санхүүгийн бус хөрөнгө	208,820	142,851
Өмч, барилга, тоног төхөөрөмж	159,237	201,788
Хөрөнгө ашиглах эрх	388,646	
Биет бус хөрөнгө	1,264	5,054
Нийт хөрөнгө	66,167,456	61,171,991
Өр төлбөр		
Даатгалын гэрээний өр төлбөр	13,948,979*	11,764,967
Бусад санхүүгийн өр төлбөр	34,375	27,992
Түрээсийн өр төлбөр	408,897	
Орлогын татварын өглөг		410,855
Хойшлогдсон татварын өр төлбөр	30,106	20,893
Нийт өр төлбөр	14,422,357	12,224,707
Өмч		
Хувьцаат капитал	24,500,000	24,500,000
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	4,186,962	4,186,962
Хуримтлагдсан ашиг	4,058,137	1,260,322
Нийт өмч	51,745,099	48,947,284
Нийт өр төлбөр ба өмч	66,167,456	61,171,991

* Компанийн санхүүгийн байдлын тайлан дахь дараах хөрөнгө өр төлбөрийг СТОУС 17.78-ын шаардлагын дагуу ангилж толилуулсан.

* Даатгалын гэрээний бүлэг тус бүрийн хувьд даатгалын гэрээний хөрөнгө болон даатгалын гэрээний өр төлбөрийг нийт дүнгээр толилуулсан байсныг 1,640,168 мянган төгрөгөөр цэвэрлэж толилуулсан.

IBDO

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг ИБДОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм үү заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд тайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэн байхдаа удирдлага нь Компанийг тэгэн буулгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байгаа бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсвөлөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадварыг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсвөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсвөлийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байж гэмтээс баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлээхээрээ санхүүгийн тайлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн үг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хяналттай бөгөөд зохистой аудитын нотлоогоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлангах, дотоод хяналтыг үл ойлгох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.

IBDO AIBT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of IBDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the International IBDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцаагүй хамтын олоо БОО АИБТ ХХК нь Их Ерөнхийн Нэгдсэн Вант Улсын IBDO Интернационал Лимитеддэй гишүүн, олон улсын IBDO сүлжээний Бие даасан гишүүн Байгууллагад нэг юм.

4

IBDO

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Мөн олж авсан аудитын нотлогод үндэслэн Компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварыг мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсвөлийн суурийг үнэлдэгээ зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудитын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудитын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотлогод суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийн өөдрөг төсвөлөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйцэтгэж ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цэр хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харицдаг.

Энэхүү хараат бус аудитын тайлангийн эцсийн үр дүнг хариуцах гэрээт ажлын партнер нь Д.Батсуурь болно.

Д.Батсуурь
БДО Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Парисын гудамж, Нарны зам-62
Юнэон Биолдинг В блок, 1502 тоот өрөө

IBDO АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Огноо: 2025.02.11

IBDO AIBT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of IBDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the International IBDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцаагүй хамтын олоо БОО АИБТ ХХК нь Их Ерөнхийн Нэгдсэн Вант Улсын IBDO Интернационал Лимитеддэй гишүүн, олон улсын IBDO сүлжээний Бие даасан гишүүн Байгууллагад нэг юм.

6

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ



☎ 7577-0002

✉ info@mongolianre.com

🌐 <http://mongolianre.com/>



📘 <http://facebook.com/mongolianre>

📷 <http://instagramm.com/mongolianreinsurance>

📺 <http://youtube.com/@mongolianre6433>

🌐 <http://linkedin.com/company/mongolian-re>

🐦 http://twitter.com/Mongolian_Re